



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 455

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн банкны хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 130,653,049.00 (нэг зуун гучин сая зургаан зуун тавин гурван мянга дөчин есөн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Төрийн банкны гүйцэтгэх захирал Г.Дөлгөөнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

000222

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
455 дугаар тогтоолын хавсралт



Төрийн банкны үндсэн хөрөнгөд
бүртгэх барилга

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Байршил	Талбайн хэмжээ м.кв
1	Тооцооны төвийн барилга	2017	130,653,049.00	Сэлэнгэ аймаг Цагааннуур сумын 3-р багийн Шинэтөв 6 гудамжны 601-А тоот	100.4
	Дүн		130,653,049.00 (нэг зуун гучин сая зургаан зуун тавин гурван мянга дөчин есөн)		